

Сосорбарамын Хүрэлсүх¹, Гэлэгдоржийн Эрэгзэн¹

¹Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн 1 байр

Бүрдний элсний оршуулга

Хураангуй. Дундад зууны Монголчууд талийгаачдаа оршуулахдаа чулуун дараастай булш, хадны оршуулга, элсний оршуулга, бунхант оршуулга зэрэг хэд хэдэн өөр хэлбэрүүдийг зэрэгцүүлэн ашиглаж байсныг археологийн биет хэрэглэгдэхүүнээс тодорхой харж болно. Тэдгээр олон хэлбэрүүдээс энэ удаа төдийлөн элбэг тохиолдоод байдаггүй элсний нэгэн оршуулгын талаар тусгайлан авч үзэв. Бүрдний элсний оршуулгын модны үлдэгдлээс дээж авч АНУ-ын Мичиганы Их Сургуулийн “Ancient Protein and Isotope” лабораторид илгээж ¹⁴C-ийн шинжилгээ хийлгэхэд үнэмлэхүй он цагийг дундаж магадлалаар НТ 1202 он хэмээн тодорхойлсон юм. Түүхэн үечлэлээр Их Монгол улсын үед холбогдох энэхүү элсний оршуулгыг нутгийн иргэний мэдээллийн мөрөөр 2021 онд Увс аймгийн Тэс сумын нутаг Бүрдний элс хэмээх газарт малтан шинжилсэн юм.

Түлхүүр үг: Их нууруудын хотгор, элсний оршуулга, Их Монгол улс

Khurelsukh Sosorbaram¹, Eregzen Gelegdorji¹

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

Sand burial of the Great Mongol


Abstract. It can be clearly seen from the archeological site that medieval age Mongols used several different forms of burial, such as stone-lined graves, rock burials, sand burials, and mural tomb.

This sand burial of Burdnii was discovered in 2021 in Tes sum, Uvs province, Mongolia. Among those many types, this time, a sand burial related to the Great Mongol, which is not very common, is discussed in detail. We have had samples from sand burial subjected to dating analysis (¹⁴C) in the the Ancient Protein and Isotope Laboratory at the University of Michigan. As a result, AD 1200-1222, median probability AD 1202.

Keywords: Sand burials, Great Mongols

Дундад зууны Монголчууд талийгаачдаа оршуулахдаа чулуун дараастай булш, хадны оршуулга, шороон дараастай булш, элсний оршуулга, оруулмал оршуулга, бунхант оршуулга, чандарлах зэрэг хэд хэдэн өөр хэлбэрийг ашиглаж байсныг археологийн биет хэрэглэгдэхүүнээс

тодорхой харж болно. Тэдгээр олон хэлбэрээс төдийлөн элбэг тохиолдоод байдаггүй элсний нэгэн оршуулгын талаар онцлон авч үзэв. Энэхүү оршуулгыг нутгийн иргэний мэдээллийн мөрөөр 2021 онд Увс аймгийн Тэс сумын нутаг Бүрдний элс хэмээх газарт (Зураг 1) малтан шинжилсэн юм.




Зураг 1. Газрын зурагт элсний оршуулгын байршилг харуулсан нь

Малтлага судалгаа. Бүрдний элс хэмээх газар эртний монголчуудын оршуулгын нэгэн хэлбэр болох “манханд суулгах” буюу элсний оршуулга салхиар ил гарсан байсныг 2021 оны 05 сард Тэс сумын харьяат Ч.Мөнхтулга хонь хариулах явцдаа олж мэджээ. Тэрбээр энэ талаараа 07 сард ШУА-ийн Археологийн хүрээлэнд мэдээ ирүүлсэн юм. Энэхүү мэдээллийн мөрөөр авран хамгаалах судалгааны баг 2021 оны 08 сарын 24-аас 30-ийг хүртэл хугацаанд авран хамгаалах малтлага судалгааг гүйцэтгэсэн [Хүрэлсүх нар, 2021: 18-26]. Уг оршуулга Увс аймгийн Тэс сумын төвөөс урагш 30 гаруй км зайд өндөр элсэн манхны баруун урд бэлд байрлана. Малтлагаар талийгаачийг зүүн хойш 35° хэмд хандуулсан оршуулга илэрсэн. Талийгаачийг 165 см урттай, 50 см өргөн, хөл талдаа 35 см өргөнтэй нимгэн банзан авсанд тэнэгэр байдлаар дээш харуулан, хоёр гарыг ташаан дээр, хоёр хөлийг уртааш шулуун жийлгэж тавьжээ (Зураг 2).

Авсны гадна талийгаачийн зүүн мөрний харалдаа дээр төмөр толь (Зураг 5а), түүний дээр үзүүрийг нь хойш харуулсан төмөр зэв (Зураг 5а), хүзүүнээс зассан чулуун зүүлт (Зураг 3),

дээл хувцасны бөс даавууны үлдэгдэл илэрсэн (Зураг 4). Талийгаачийн хүзүүнээс цэнхэр өнгийн 2, улаавтар хүрэн өнгийн 5 ш зассан чулуун зүүлтийн сувс зарим нь хэлхээтэйгээ (Зураг 8), гавлын зүүн талд төмөр толь, зэвийн харалдаа доороос богийн дал тавьсан (зураг 5а) ба хүний ясыг авах явцад аарцгийн доороос богийн нурууны яс буюу харцага 2 үе нугалам илэрсэн (Зураг 5б). Талийгаачийн хөл талд буюу оршуулгаас урагш 1,2 м зайд шавар ваарын амсар цухуйж байсныг гүнзгийлэн малтахад босоо амсартай, бөөрөөрөө цүлхгэр, хавтгай ёроолтой бүтэн ваар илэрсэн. Ваар мөрнөөс дээгүүрээ “иржийлгэсэн” нарийн товгор хээтэй (Зураг 6). Ваарын өндөр 32 см, өргөн 16 см. Элсэнд органик гаралтай материал харьцангуй сайн хадгалагддаг бөгөөд эл оршуулгаас дээл хувцасны захны хэсэг илэрсэн. Дээлийн захыг бүдүүн утсаар хөндлөнгөөр “загасан нуруу” маягаар сүлжиж, хоёр давхарлан эгнүүлжээ (Зураг 9). Хүний ясыг авахад дээлийн үлдэгдэл нурууны хэсэг болон зүүн гарын яс даган илэрч байв. Нарийн захан мод илэрсэн нь оршуулгын нимгэн банзан авсны шалыг савхан модоор хийснийг илтгэж байна.



Зураг 2. Элсний ориуулгыг малтсан нь



Зураг 3. Хүзүүний зүүлт илэрч буй нь



Зураг 4. Ориуулгаас торгон дээлийн зах илэрч буй нь



Зураг 5. а. Талийгаачийн зүүн мөрний харалдаа авсны гадна төмөр толь, зэвийг, эдгээрийн цаана хонины дал, б. Хүний аарцгийн доороос хонины нуруу яс илэрсэн нь



Зураг 6. Талийгаачийн хөл талд оршуулгаас урагш 1,2 м зайд дагалдуулж тавьсан ваар



Зураг 7. а. Навчин хэлбэрийн төмөр зэв, б. Зэвийн сурвалжид мөс буюу модны ширхэг наалдаж үлдсэн нь, в. Төмөр толь, г. Хүрэл сэнжстэй эзэмэг



Зураг 8. Чулуу болон хув хэлхсэн зүүлт

Олдворын тодорхойлолт. *Төмөр зэв.* Зэв 15 см урттай, 5 см өргөн. Үүнээс зэв 10 см, сурвалж 5 см урттай. Зэв навчин хэлбэртэй. Нэг жигүүр хагарч эмтэрсэн. Сурвалж хэсэгтээ мөсөнд зоож байсан учраас модны ширхэг наалдаж үлдсэн (Зураг 7а, 7б).

Төмөр толь. 15 см голчтой. Нүүрэн тал тэгш хавтгай. Ар талд нь хүрээг товгор ирмэг гаргасан байх ба хүрээнээс дотогш 2 см зайд үл мэдэг ховилтой. Бариулын ул мөр тодорхой мэдэгдэхгүй байна. Уг толийг даавуун уутанд хийж тавьсан бололтой даавууны үлдэгдэл ард 2 хэсэгт, нүүрэн талд 2-3 хэсэгт, хүрээний ирмэгт мөн наалдаж үлдсэн ул мөртэй (Зураг 7в).

Хүзүүний зүүлт. Сондор хэлбэртэй улаан өнгийн зассан чулуу 2ш. Улаан өнгөтэй, эрхин буюу сондор хэлбэртэй мэт боловч хоёр хажуугаас хавтгайлсан. Хавтгайн голд нэвт цоолсон нүхтэй. Нүх 1 мм голчтой. Хоёр талаас хавтгайлсан ба хавтгай хэсгийг тойрсон 7 талт болгон олон талт хэлбэрт оруулан гол хэсэгт уулзуулсан. Голч 1,5 см, 1 см өргөнтэй (Зураг 8).

Тэгш өнцөгт хэлбэртэй улаан өнгийн зассан чулуу 2ш. Чулууг уртавттар нарийн тэгш өнцөгт хэлбэртэйгээр засаж, нэг талд нь уртааш тууш 3 талт болгон тэгшилж зассан ба бүтэн тойрсон байдлаар нийт 6 талт хэлбэрт оруулсан. Уртааш голд нь 2 мм голчтой нүх нэвт гаргасан. Нөгөө хос нь өнгө арай бүдэг байх ба урт нь 2,4 см, өргөн 1 см, зузаан 0,7 см хэмжээтэй. Хэлбэрийн хувьд яг ижил байна.

Хөх өнгийн сувс 2ш. Уг сувс арай тод хөх өнгөтэй. 1,1 см урт, 0,8 см өргөнтэй. Голд нь уртааш 0,3 см голчтой нэвт нүхтэй. Нөгөөх нь арай бүдэг цайвар хөх өнгөтэй. 1,2 см урт, 0,7 см өргөн. 0,2 см голчтой нүхтэй.

Торгон дээлийн үлдэгдэл. Оршуулганд шарилыг дээл хувцастай нь тавьсан нь ихэд үрэгдэж авс буюу дэвсгэрийн савхан моднуудтай наалдсан хэсгүүд үлдсэн. Үлдэгдэл хэсгээс сайтар үзэхэд бор шаргал өнгийн дэвсгэр дээр хар хүрэн өнгөөр дугуй хэлбэртэй хээтэй торго байжээ. Мөн дээлийн зах хүний хүзүү хэсгээс гарсан ба нарийн хатгамалтай (Зураг 9).

Хүрэл голтой эмэг. Чихэнд зүүх нарийн сэнж хугарсан. 2 см урттай. Унжлага 1 см өндөр, 0,8 см өргөн. “Лийр” маягийн хэлбэртэй. Дээрээс нь доош голлуулж нэвт нүх гаргаж хүрэл утсаар сүвлэн үзүүрийг нь унжлаганы гадуур дээш нугалан сэнжний хэсгээс ороож бөхөлсөн. Хүрэл утас 2 мм-ийн өргөнтэй. Унжлагыг сайтар ажиглавал цууралт мэдэгдэх бөгөөд ширхэг нягт модоор хийсэн болов уу гэлтэй харагдана (Зураг 7г).

Авс модны үлдэгдэл. Малтлагаас гарсан моднууд авсных гэхээсээ илүүтэй шарилд дэвсгэр болгож тавьсан модны хэсгүүд бололтой. Дэвсгэрийг

хийхдээ нарийн урт моднуудаар хүрээ зангидаж, хөндөл моднууд шаантаглан дээр нь уртааш нарийн савхан моднуудыг эгнүүлэн өрсөн байна. Савхан мод 0,5-1 см өргөнтэй.

Вааран сав. Уг ваар босоо амсартай, бөөрөөрөө цүлхгэр, хавтгай ёроолтой бүтэн ваар илэрсэн. Ваар мөрнөөс дээгүүрээ ташуудуу иржийлгэсэн нарийн товгор хээтэй. Ваарны өндөр 32 см, өргөн 16 см (Зураг 6).

Судалгааны хэлэлцүүлэг

Манай улсын нутаг Их нууруудын хотгор, тал хээрийн, говийн бүс дагасан элсэн манхнаас эртний нүүдэлчдийн түүх, соёлын дурсгалт зүйлс цөөнгүй илэрч олддог бөгөөд өнөөгийн байдлаар зөвхөн оршуулгын зан үйлтэй холбогдох дурсгал хүннүгээс [Эрэгзэн нар, 2023: 178] эхлэн сяньби [Амартүвшин нар, 2015: 272-279], түрэгийн үеийн эмэгтэй хүний оршуулга [Амартүвшин, 2021: 66], монголын үед [Баяр, 1986: 50-68; Баатар нар, 2011: 206-207] хамаарах элсний оршуулгуудыг судлаачид шинжилж, судлан тодорхойлсон байдаг. Бидний хувьд сэдэвтэйгээ хамаатуулан Монголын үед холбогддог элснээс илэрч олдсон эд өлөг, дурсгалын талаар онцлон дурдах нь зүйтэй юм.

1986 онд Завхан аймгийн Цэцэн-Уул сумын нутаг Нахиугийн манхан хэмээх газарт мэдээллийн дагуу авран хамгаалах судалгаа хийсэн ба судлаачдыг очиход хүмүүс оршуулгыг сүйтгэсэн байсан бөгөөд судалгаагаар ухмал модон авсны хэсгүүд, эмээлийн хавтас мод, үйсэн эдлэлийн үлдэгдэл, ялтсан хуягийн хэсэг, илдийн хугархай, мөнгөн эдлэл зэрэг зүйлсийг илрүүлжээ [Баяр, 1986: 51-52]. Эндээс илэрч гарсан хөө хуяг, мөнгөн чимэглэл, эмээлийн хавтас, авс модны хийц загвараас үзэхэд монголын үеийн дурсгалуудтай ижил байдаг. Түүнчлэн манай улсын хөрш зэргэлдээ БНХАУ-ын Хөх нуурын Цайдмын бүс нутгаас “занданшсан шарилыг урт эсгийд ороож хуурай элсэнд оршуулсан тул маш сайн хадгалагдсан байжээ. Занданшсан шарил дунд зэргийн нуруутай, сахал үс бүтэн, нуруу намхавтар, эрүүл чийрэг, хүдэр бахь төрхтэй ба шар цэцгэн хээтэй нимгэн торгоор өнгөлж хуягласан нэхий дээл, дотуураа цээжийг хамгаалсан хөнгөн хуягтай, бүсэлхийгээрээ чанга ороосон хаш шигтгээтэй урт бүстэй, дутуу боловсруулсан үхрийн ширээр хийсэн дөрөөний урт гуталтай, оройдоо улаан өнгийн нэг урт өд хатгасан дугуй хэлбэрийн ширэн дуулга толгойдоо өмссөн зэрэг сайтар хувцасласан байжээ [Баатар нар, 2011: 202]. Мөн XX зууны эхээр Шинжааны Лоб нуурын орчимд Свен Хединий удирдсан Хятад-Шведийн судалгааны ангийн хийсэн хайгуулаар Фольке Бергман 1934 онд Кумдарьяа голын зүүн савд Ярлик-көл жижиг нуураас холгүй Ярдан булгийн ойролцоо газарт элснээс оршуулга илэрч байжээ [Folke Bergman, 1939: 55-

56]. Эдгээр нэр дурдсан элсний оршуулгууд нь Монголын эзэнт гүрний үед хамаарах дурсгалууд болох ба энэхүү оршуулгын зан үйл эртнээс уламжилж, тасралтгүй ирсэн бөгөөд элсэн манхны зах дагууд нутагладаг эртний хүмүүс талийгаачийг тухайн газар орныхоо онцлог байдалтай уялдуулан нэг газар олноор нь бус ганц нэгээр нь “манханд суулгаж” байжээ. Элсний оршуулга нь нүдэнд харагдах ил байгууламж гэх зүйлгүй учир илэрч мэдэгдэх нь ихээхэн бэрхшээлтэй ба анх олдохдоо санамсаргүйгээр тохиолдлын чанартай мэдэгддэг. Тухайлбал, Хөх нуурын цайдмын оршуулга “1958 оны өвөл Номхоны тариалангийн газрын хөрсийг хуулаад, самнаж бордоодох ажиллагааны хоёр дахь шатанд эртний занданшсан шарилыг малтаж гаргасан” [Баатар нар, 2011: 201] бол Нахиугийн манхны элсний оршуулгыг “уг газарт үхэр туусан хүн явж байтал үхэр нь тэр хавьд туурайгаараа газар малтан мөөрч орилолдоход нь очиж үзвэл элсэн доороос авс бололтой зүйл цухуйж байхыг үзсэн” [Баяр, 1986: 50] зэргээр дурдсан байдаг. Харин өгүүлэн буй Бүрдний элсний оршуулгыг “салхиар элс нүүж оршуулга ил гарсан байсныг нутгийн иргэн хонь хариулах явцдаа олж” мэджээ. Иймээс элсний оршуулгыг урьдаас төлөвлөн судалж, шинжлэхэд барагтайхан тул бусад судлаачдын “цаашид энэ чиглэлд анхаарлаа илүүтэй хандуулж, дараасгүй буюу газрын хөрсөн дээр ямар нэгэн таних тэмдэггүй булш

оршуулгыг илрүүлэн олохдоо тухайн бүс нутгийн газар орны нөхцөл байдалд тулгуурласан арга зүй, аргачлалыг боловсруулах, мэдээллийн санг бүрдүүлэх, түүнд тулгуурласан зайнаас тандах, урьдчилан таамаглах боломжийг бий болгох нь зүйтэй” хэмээн өгүүлсэнтэй [Амартүвшин, 2023: 48] санал нэг байна. Элсний оршуулгын судалгааны тойм байдлаас үзэхэд ерөнхийдөө хүрэл зэвсгийн үеэс эхлэн элсэнд оршуулах зан үйлийн уламжлал Монгол нутагт тасралтгүй үргэлжилж байсныг харж болох бөгөөд XVII-XVIII зууны үе хүртэл талийгаачийг уутанд хийж элсэнд оршуулахыг “манханд суулгах” хэмээн нэрлэж байжээ [Хурцбилэг, 2003: 140]. Дээр дурдсан монголын үед хамаарах элсний оршуулгуудыг харьцуулан авч үзэхэд элсэн манханд нэг доор олноор нь бус зөвхөн ганц нэгээр тавьсан байх бөгөөд тухайн үеийнхээ нийтлэг зан үйлийн дагуу талийгаачийг хувцастай нь зүүн хойш хандуулж, эд өлгийн зүйлсийг дагалдуулж, хойлгын зан үйлийн гол элемент болох хонины хоёр үе “нуруу яс”-ыг хүний аарцгийн доор газрыг хонхойлгон ухаж тавьжээ.

Холбогдох он цаг. Бүрдний элсний оршуулгын авс модны үлдэгдлээс дээж авч АНУ-ын Мичиганы Их Сугруулийн “Ancient Protein and Isotope” лабораторид илгээж ^{14}C -ийн шинжилгээ хийлгэхэд үнэмлэхүй он цагийг дараах байдлаар нарийвчлан тогтоолоо.

Radiocarbon Age BP	850 +/- 20	
Calibration data set:	intcal20.14c	
% area enclosed	cal AD age ranges	# Reimer et al. 2020 relative area under probability distribution
68.3 (1 sigma)	cal AD 1177- 1194 1200- 1222	0.419 0.581
95.4 (2 sigma)	cal AD 1163- 1230 1243- 1258	0.943 0.057
Median Probability:	1202	

Бүрдний элсний оршуулгын зан үйлийн зарим элементийг бусад өөр хэлбэрийн булштай харьцуулж үзэхэд XII-XIV зууны үед хамаатуулан авч үздэг “монгол булш”-тай адил талийгаачийг зүүн хойш хандуулсан ба тэнэгэр байдлаар дээш харуулан хоёр гарыг их биеийн дагуу, хоёр хөлийг уртааш жийлгэж тавьжээ. Мөн хонины далыг талийгаачийн толгой талд зүүн мөрний доор, хоёр үе нуруу ясыг аарцгийн доор тавьсан хойлгын зан үйлээрээ ихээхэн төстэй байна. Тухайлбал, монгол булшнаас богийн буюу “хонины дал нийт 54 булшнаас илэрсэн бөгөөд тэдгээрийн 14 булшны хэрэглэгдэхүүн анхны тавилтаас хөндөгдөж, 40 булшнаас анхны байрнаас хөндөгдөлгүй хадгалагдан үлджээ. Булшинд далыг хүний аль талд тавьсныг 40 булшны хэрэглэгдэхүүнээс харвал хүний баруун талд 21 (52%), зүүн талд 19 (48%) тохиолдох бөгөөд нарийвчлан үзвэл хүний

баруун мөрний хажууд 2, баруун мөрөн дээр 1, баруун талд цээжний тушаа 1, хүний толгойн баруун хойд талд 15, толгойн баруун талд 2, зүүн мөрний хажууд 2, зүүн талд цээжний тушаа 3, зүүн бугалгын хажууд 1, хөлийн зүүн урд талд 3, хүний толгойн зүүн хойд талд 10 булшинд тус тус тохиолдож” байжээ [Батдалай, 2024: 96]. Хонины дал ясны тухай шүтлэг бишрэл монголчуудын дунд аль эртнээс эхлэн өөрийн байр суурь, нөлөө тусгалаа олсон гэдгийг олон баримтаар ойлгон мэдэх боломжтой. Тухайлбал, дал нь өнөө цагт ч хүндэтгэлтэй идээнд тооцогдон ахмад настайчууд буюу хүндэт зочин, төрөл садан, эрхэм тушаалтан нарыг хүндлэн дээдэлж, зочлон дайлахдаа далыг бусад махны хамт заавал гаргаж, тэд нарыг хүндлэн дээдэлж байгаагаа илэрхийлж байгаа ёс юм. Ингээд настай хүн даланд гар хүрэхээс өмнө өөр хүн гар хүрч болохгүй. Далны махыг ганцаараа

идэж болохгүй харин «далны махыг даяараа идэж, далдхан үгээ ил хүүрнээ» гэж хүн бүхэнд далны махыг амсуулдаг ажээ [Гомбожав, 2002: 448]. Мөн монгол булшинд “хонины нуруу ясыг 2-3 үе нугалмаар хамгийн олон тоогоор дагалдуулах ба ихэвчлэн талийгаачийн нурууны тушаа, газар хонхойлгон ухаж байрлуулж, дээр нь хүнээ тавин оршуулдаг бөгөөд дагалдуулах нурууны тоо зэргээс үзвэл энэ нь тогтсон зан үйл байсан бололтой” хэмээн энэхүү хойлгын элементийн зүй тогтол, агуулгын талаар нарийвчлан авч үзсэн байдаг [Түвшинжаргал, 2012: 135].

Лабораторийн болон оршуулгын зан үйл, хойлгын зан үйлийн эдгээр элементээс гадна эд өлгийн зүйлсийг нь бусад хэрэглэгдэхүүнтэй харьцуулан үзэхэд Бүрдний элсний оршуулга нь Их Монгол улсын үед холбогдож байгаа ба оршуулгаас илэрсэн дээлийн захтай (Зураг 9) ижил дээл уг дурсгалаас зүүн тийш орших Дархадын хотгорын алдарт Хориг-2 уулын 39 дүгээр булшнаас (Зураг

10а) [Баярсайхан нар 2023, 266-269] олдсон. Мөн ОХУ-ын нутаг Тормосин фермийн ойролцоох газрын 1-р булшнаас илэрсэн Алтан ордны улсын үед холбогдох олдвор (Зураг 10б) зэрэгтэй оёж хатгасан байдал нь тун төстэй байна.

Эдгээр торгон дээлийн үлдэгдэл хэсгүүдийг харьцуулан үзэхэд хэдийгээр бүрэн бүтэн биш боловч дээлийн захад бүдүүвтэр утсаар 0,5 см өргөнтэйгөөр босоо чиглэлд давхардуулалгүй маш цэгцтэйгээр тэгшхэн зайгүй эгнүүлэн хатгаж оёсон байх ба түүнийгээ давхардуулан оёж, улам илүү гоёмсог болгожээ. Ийнхүү гоёж чимэглэсэн байдлыг нарийвчлан үзэхэд эмжээр байдлаар хийж, нимгэн нарийн арьсыг торгонд барьж, түүнийгээ ороох маягаар цаад торготой хатгамал маягаар оёсон ажээ.

Бүрдний элсний оршуулгаас XIII зууны үеийн монгол эмэгтэй хүний гоёл чимэглэлийн чухал хэрэгсэл болох зүүлт илэрсэн (Зураг 8) ба малтах явцад нарийн эрчилсэн утсанд хэлхсэн байв.



Зураг 9. Бүрдний элсний оршуулгаас илэрсэн торгон дээлийн зах



Зураг 10. а. Хориг-2 уулын 39-р булш (© Ж.Баярсайхан), б. ОХУ-ын нутаг Тормосин фермийн ойролцоох газрын 1-р булшнаас илэрсэн Алтан ордны улсын үед холбогдох олдворын (© С.М.Шашунова) хатгамалтай хэсгүүд

Зүүлтийг сондор хэлбэртэй улаан өнгийн зассан чулуу 2, тэгш өнцөгт хэлбэртэй улаан өнгийн зассан чулуу 2, хөх өнгийн сувс 2 тус бүрдээ хэлбэр болон өнгөний байдлаараа хосолсон нийт 6 тооны сондортой. Үүнтэй адил зүүсгэл Их Юань улсын үед холбогдох Нартын хадны оршуулгаас [Хүрэлсүх нар, 2022: 141], мөн алдарт Хориг уулын булшнаас үнэт чулуу, сувдан чимэглэлүүд олддог [Баярсайхан нар, 2023: 312-313]. Монгол булшны нэгэн адил сав суулгын төлөөлөл болох вааран сав илэрсэн бөгөөд уг савыг талийгаачийн толгой тал, хажуу талд бус хөл талд буюу оршуулгаас урагш 1,2 м зайд тавьсан нь сонирхолтой байна.

Товч дүгнэлт

Монголчууд эртнээс тухайн нутаглан буй газар орныхоо байгалийн тогтоц, орчин нөхцөлдөө таацуулан элстэй газарт “манханд суулгах” буюу элсэнд оршуулах зан үйл эрт үеэс мэр сэр хэрэглэж байсныг археологийн судалгааны цөөнгүй үр дүнгээс харж болно. Өөрөөр хэлбэл, элсэнд оршуулах зан үйлийг системтэйгээр өргөн бүс нутагт бус тэрүүхэн хэсэгхэн, зурвас элстэй газар нутагтаа нөхцөлдүүлэн маш бага хэмжээнд ашиглаж байжээ гэдгийг тодотгох нь зүйтэй. Түүнчлэн манай орны хувьд элстэй газарт хүн амьдарч нутаглах нь харьцангуй бага тул элсний нүүдэл зэргээр эртний оршуулга ил гарч ирлээ гэхэд түүнийг тухай бүрд нь хүн мэдэх бололцоо маш бага, нөгөө талаар мал, амьтны хөлөөр гэмтэж сүйдэх магадлал ихтэй тул ихэнхдээ хөндөгдсөн, сүйдсэний дараа, хэзээ хойно олж мэдэх нь дийлэнх байдаг. Бүрдний элсний оршуулгыг харин устаж сүйдэхээс нь өмнө цаг алдалгүй судалж чадсан бөгөөд одоогоор манай улсын нутгаас бүрэн бүтэн олдсон элсний оршуулгын цөөн хэдэн тохиолдлын нэг болж байна. Уг элсний оршуулгын холбогдох он цагийн үр дүн болон зан үйлийн элементүүд болох хонины дал, нуруу ясыг дагалдуулж тавьсан нь Их Монгол улсын үеийн оршуулга болохыг илтгэж байна. Мөн торгон дээлийн үлдэгдэл болох захны хэсгийн хатгамал, чулуун зүүлт зэрэг нь тухайн хүний угсаа гарлыг орон нутгийн язгууртан байх боломжтойг давхар харуулав.

Бүрдний элсний оршуулгын дурсгал нь эртний монголчуудын оршуулгын олон хэлбэрийг төрөлжүүлэн нарийвчлан судлахад гол хэрэглэгдэхүүн болох ба элсний оршуулгын судалгаанд ач холбогдол өндөртэй байх нь дамжиггүй. Тухайлбал, бидний үзэхэд хамгийн чухал нь Их Монгол улсын үед оршуулгын олон хэлбэр, зан үйлийг хэнд, хаана, ямар эрэмбэ дараа болон тухайн газар орны нөхцөл байдалд тохируулан үйлддэг байсныг тодруулахад чухал хэрэглэгдэхүүн болох юм. Нөгөө талаар энэ нь оршуулгын соёлын олон хэлбэрийг нэг төрөлд

буюу тогтсон нэг зан үйлд хэрэглэдэг байхаар “хуульчлан” тогтоолгүй тухайн газар орны уламжлал, онцлогтоо тохирсон оршуулах зан үйлийн хэлбэрийг (төрийн зүгээс шашныг ялгаж үзэлгүй тэгш хандаж байсантай нэгэн адил) сонголттойгоор хэрэглэх боломж “чөлөөтэй” гэмээр байжээ.

Эцэст нь тэмдэглэхэд судлаачдын өгүүлсэнчлэн “цаашид өөрийн орны элсэн тарамцаг, манхнуудын талаарх газар зүйн мэдээллийн санг бий болгох, археологийн хайгуулыг тухайн нөхцөл байдалд тохирсон арга зүйд тулгуурлан хийж гүйцэтгэх, энэ чиглэлээр орон нутгийн иргэдийн мэдээллийг цуглуулах, угсаатны зүйн судалгааг нэмэлт байдлаар гүйцэтгэх шаардлага урган гарч байна” [Амартүвшин, 2021: 69] хэмээн өгүүлсэн нь зүйтэй бөгөөд Монгол нутаг дахь элсний оршуулгын дурсгал, материал хэрэглэгдэхүүн хуримтлагдахын хэрээр тухайн хэлбэрийг тусгайлан авч үзэж, уламжлалт байдал, хувьсал өөрчлөлт, онцлог байдлыг нь тодруулан гаргах, цаашлаад бүс нутгийн хүрээнд харьцуулах шаардлага тулгарч байна.

НОМ ЗҮЙ

Амартүвшин, Ч. Майхант уулын дурсгал ба элсний оршуулга. *Studia Archaeologica*. Instituti Archaeologici Academiae Scientiarum Mongolicae. Tomus XL, fasc. 7, УБ., 2021: 60-71.

Амартүвшин, Ч. Монголчуудын элсний оршуулгын зан үйлийн асуудалд. *Монголчуудын хойлгын зан үйл: Уламжлал, орчин үе, чиг хандлага. Эрдэм шинжилгээний III хурлын эмхэтгэл*. Улаанбаатар, 2023: 36-58.

Амартүвшин, Ч., Батзориг, О. Булан тойромын булш. *Studia Archaeologica*. Tomus XXXV, fasc. 24, Улаанбаатар, 2015: 272-279.

Баатар, Ш., Эрдэнэбат, У. Хөхнуурын Цайдамаас олдсон монгол баатрын занданшсан шарил. *Studia Archaeologica*. Tomus XXX, fasc. 11, Улаанбаатар, 2011: 205-221.

Батдалай, Б. *X-XVII зууны монгол булш, оршуулгын судалгаа (Монгол улсад малтсан хэрэглэгдэхүүнээр)*. Түүхийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. УБ., 2024.

Баяр, Д. Түүхийн хүрээлэнгээс Завхан аймгийн Цэцэн-Уул суманд мэдээ шалгах зорилгоор явуулсан хайгуул ажлын үр дүнгийн тухай. *Монголын археологи: Хээрийн судалгааны тайлан (1986-1987 он)*. УБ., 2016: 50-67

Баярсайхан, Ж., Кларк, Ж., Түвшинжаргал, Т., Бямбадорж, Б., Содномжамц, Д., Бямбажаргал, Б. *Хориг уулын эрдэнэс*. Улаанбаатар, 2023.

Гомбожав. Дал шинжилгээний уламжлал бэлгэдэл (Шинжааны Баянголын монголчуудын жишээгээр). *Монголоведение*. Т. 12, № 3, 2020: 446-454.

Bergman, F. Archaeological Research in Sinkiang: Especially the Lop-nor Region. *Reports from the Scientific Expedition to the North-Western Provinces of China under the Leadership of Dr. Sven Hedin. The Sino-Swedish Expedition*. Publication 7: VII, Archaeology 1, Stockholm. 1939.

Түвшинжаргал, Т. Дундад эртний үеийн булшинд бог малын нуруу дагалдуулах зан үйлийг мөшгөх нь. *Mongolian journal of Anthropology, Archaeology and Ethnology*. Vol. 7, No 1 (378), УБ., 2012: 134-142.

Хурцбилэг, Н. *Монголчуудын оршуулгын соёл*. Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хороо, Хөх хот, 2003.

Хүрэлсүх, С., Мөнхтулга, Р. Нартын хадны дурсгал. “Монголын Археологийн өв” цувралын XIII боть “Монголын хадны оршуулгын дурсгал” эрдэм шинжилгээний каталог. УБ., 2022: 134-141.

Хүрэлсүх С., Эрэгзэн, Г., Батболд, Н., Анхбаяр, Б. Ховд, Увс аймгийн нутагт ажилласан археологийн авран хамгаалах судалгааны ажлын тайлан. АХГБСХ., УБ., 2021.

Шашунова, С. М. Золотоордынский текстиль в коллекции Волгоградского областного краеведческого музея. Искусство древнего текстиля. Методы изучения, сохранность, реконструкция. Оппенхайм-на-Рейне. 2019: 223-239.

Эрэгзэн, Г., Хүрэлсүх, С., Цолмон, Б. “Монголын эзэнт гүрний археологи” захиалгат төслийн хүрээнд Завхан аймгийн нутагт явуулсан археологийн авран хамгаалах судалгааны товч үр дүн. “Монголын археологи-2023” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2023: 178-181.

REFERENCES

Amartüvshin Ch. Maikhant uuliin dursгал ba elsnii orshuulga. *Studia Archaeologica*. Institutii Archaeologici Academiae Scientiarum Mongolicae. Tomus XL, fasc. 7, Ulaanbaatar, 2021: 60-71.

Amartüvshin Ch. Mongolchuudiin elsnii orshuulgiin зан үйлийн асуудал. [A burial ritual of the ancient Mongols] 4th Academic Conference on Mongolian Funerary Rituals. Ulaanbaatar, 2023: 36-58.

Amartüvshin Ch., Batzorig, O. Bulan toiromiin bulsh. *Studia Archaeologica*. Tomus XXXV. fasc. 24, Ulaanbaatar, 2015: 272-279.

Baatar Sh., Erdenebat, U. Khökh nuuriin Tsaidamaas oldson mongol baatarin zandanshan sharil. *Studia Archaeologica*. Tomus XXX. fasc. 11, Ulaanbaatar, 2011: 205-221.

Batdalai, B. *X-XVII зуunii mongol bulsh, orshuulgiin судалгаа (Mongol ulsad maltsan khereglegdekhüüneer)*. Түүкхиин укхаанii докториин (Ph.D)-iin zereg gorilson бүтээл. Ulaanbaatar, 2024.

Bayar, D. Түүкхиин khureelengees Zavkhan aimgiin

Tsetsen-Uul sumand medee shalgakh zorilgoor yavuulsan khaiguul ajliin ür дүнгийн тухай. *Mongoliin archaeology: Kheeriin судалгаанii тайлан (1986-1987 он)*. Ulaanbaatar, 2016: 50-67.

Bayarsaikhan, J., Clark, J., Tüvshinjargal, T., Byambadorj, B., Sodnomjamts, D., Byambajargal, B. *Treasures of Khorog Mountain*. Ulaanbaatar, 2023.

Gombojav. Dal shinjilgeenii ulamjal belgedel (Shinjaanii Bayangoliin mongolchuudiin jisheegeer). *Монголоведение*. Т. 12, № 3, 2020: 446-454.

Bergman, F. Archaeological Research in Sinkiang: Especially the Lop-nor Region. *Reports from the Scientific Expedition to the North-Western Provinces of China under the Leadership of Dr. Sven Hedin. The Sino-Swedish Expedition*. Publication 7: VII, Archaeology 1, Stockholm. 1939.

Tüvshinjargal, T. Dundad ertnii üeiin bulshind bog maliin nuruu dagalduulakh зан үйлийг мөшгөх нь. *Mongolian journal of Anthropology, Archaeology and Ethnology*. Vol. 7, No 1 (378), Ulaanbaatar: 134-142.

Khurtsbileg, N. *Mongolchuudiin orshuulgiin soyol*. Üvür Mongoliin soyoliin khvleliin khoroo. Khökh khot, 2003.

Khürelsükh, S., Mönkhtulga, R. Nartiin khadnii dursгал. *Archaeological Relics of Mongolia catalogue series. Rock burials of Mongolia. 13 volume*. Ulaanbaatar, 2022: 134-141.

Khürelsükh, S., Eregzen, G., Batbold, N., Ankhubayar, B. Khovd, Uvs aimgiin nutagt ajillasan archaeologiin avran khamgaalakh судалгаанii ajliin тайлан. Ulaanbaatar, 2021.

Shashunova, S.M. *Zolotoordiinskii tekstili v kolleksii Volgogradskogo oblastnogo kraevedcheskogo muzeya*. Iskusstvo drevnego tekstiliya. Metodi izucheniya, sohrannosti, rekonstrutiya. Oppenheimer na Reine. 2019: 223-239.

Eregzen, G., Khürelsükh, S., Tsolmon, B. “Mongoliin ezent гүрний archaeology” zakhialgat tösliin khüreend Zavkhan aimgiin nutagt yavuulsan archaeologiin avran khamgaalakh судалгаанii товч үр дүн. “Mongoliin archaeology-2023” erdem shinjilgeenii khurliin emkhetgel. Ulaanbaatar, 2023: 178-181.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>